



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 276 дугаар тогтоол, 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 5 дахь заалт, Журамд өөрчлөлт оруулах тухай 491 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1649 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээнд өөрчлөлт орсонтой холбогдуулан батлагдсан цалингийн санд багтаан Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2.Шинэчлэгдсэн цалингийн хэмжээг Хүний нөөцийн болон Цалингийн нэгдсэн системд бүртгэж оруулан Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдад 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ